БАТЛАВ

ДАРГА Н.ГАНТУЛГА

2023 оны .....сарын....өдөр

# БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДОТООД ХЯНАЛТ-ШАЛГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

2023.06.05

ЗОРИЛГО: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан тушаал, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч эрсдэлийг бууруулах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад чиглэгдэнэ.

ХУГАЦАА: 2023 оны 06 дугаар сарын 05-ний өдрөөс 06 дугаар сарын 09-ны өдрийг дуустал зохион байгуулна.

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН: Ахлагч /Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарын бодлогын хэрэгжилт, хүний нөөц, дотоод хяналт шалгалт, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн/, гишүүн /Архив бичиг хэргийн эрхлэгч, нярав/-аас бүрдэнэ.

ШАЛГАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Бүх албан хаагчид

ШАЛГАЛТЫН АРГА, ХЭЛБЭР, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилт, Сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, удаашралттай ажлуудыг эрчимжүүлэх чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах, хэрэгжүүлж буй захирамжлалын баримт бичиг, албан хэргийн шийдвэрлэлт, иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол, өргөдөл, гомдол шийдвэрлэлт, байгууллагын архив, бусад эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн явц, байгууллагын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалт, хадгалалтын үйл ажиллагаанд тавих хяналт, санхүүгийн ил тод байдал, иргэдийн үйлчлүүлэх таатай орчин, ажлын байрны

аюулгүй байдал эрүүл ахуйн чанар хангасан байдал, албан хаагчдын ажлын байрны эмх цэгц, ажлын төлөвлөлт, гадуур ажлын тэмдэглэлтэй тус тус танилцана.

- Хяналт шалгалтын үйл ажиллагааны явц болон илэрсэн зөрчлийг холбогдох бичиг баримт, фото зураг, дүрс бичлэг хийж баталгаажуулна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДҮНГ НЭГТГЭН ТАЙЛАГНАХ

Ажлын хэсэг хяналт шалгалтын дүнг нэгтгэж 2023 оны 06 дугаар сарын 09-ны өдөр зөвлөмж боловсруулна. Шаардлагатай бол илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан ажилтанд хариуцлага ногдуулахаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлнэ.